



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А1258

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Мобиком корпораци" ХХК-ийн захиалгаар Жаргалан сумын Хүнхэр зуслан, Хөхморьт сумын Дөргөн нуурт үүрэн холбооны сүлжээний зориулалтаар баригдсан 15м өндөр төмөр цамхаг угсралтын ажлыг хүлээн авч байнгын ашиглалтад оруулах үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)

Гишүүдэд: М.Мандаххүү (Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

З.Жаргалтуяа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, хэлтсийн мэргэжилтэн)

М.Мөнхцэцэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн байгууламж хариуцсан мэргэжилтэн)

Б.Ариунтөгс ("Монхас" ХХК-ийн ерөнхий инженер) (гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Д.Отгонбат ("Мобиком корпораци" ХХК-ийн инженер)


2.

2.Байгууламжийг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсаны дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, хэвийн ажиллагааг ханган, хамгаалалтад авч ажиллахыг "Мобиком корпораци" ХХК (Д.Ариунтуяа)-д зөвлөсүгэй.

4.Үүрэн холбооны операторуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хамрах хүрээ чанарын үзүүлэлтэд тогтмол хяналт тавьж хамтран ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР